

БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЭЭ

20 ... оны ... дугаар сарын ... -ны өдөр

Дугаар: Б-... /...

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас “Автотээврийн үндэсний төв” ТӨҮГ-ыг төлөөлж /цаашид гүйцэтгэгч гэх/ Судалгаа, хөгжил, чанарын удирдлагын төвийн дарга, нөгөө талаасХХК-ийг төлөөлж /цаашид захиалагч гэх/бид дараах нөхцөлөөр энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл, зорилго

1.1 “Тохирлын үнэлгээ - Бүтээгдэхүүн, үйл явц болон үйлчилгээний баталгаажуулалтын байгууллагад тавих шаардлага” MNS ISO/IEC 17065:2013 олон улсын стандартын 4.1.2 дахь хэсгийг үндэслэв.

1.2 Захиалагчийн автотээврийн хэрэгслийн засварын чиглэлээр явуулж байгаа үйлчилгээ нь “АТҮТ” ТӨҮГ-ын “Автотээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний баталгаажуулалтын схем”-ийн шаардлагад нийцэж буйг нотлох, баталгаа гаргах, хадгалахад энэхүү гэрээний зорилго оршино.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1 “Тохирлын үнэлгээ” гэж бүтээгдэхүүн, үйл явц, тогтолцооны ажилтан буюу байгууллагад хамаарах тогтоосон шаардлага хангагдсаныг нотлох;

2.2 “Баталгаажуулалт” гэж бүтээгдэхүүн, үйл явц, тогтолцоо буюу ажилтанд хамаарах хөндлөнгийн баталгаажуулалт;

2.3 “Баталгаажуулалтын схем” гэж нэг ижил тогтоосон шаардлага, дүрэм болон журам хэрэглэх тухайн бүтээгдэхүүнд хамааралтай баталгаажуулалтын тогтолцоо;

2.4 “Тохирлын гэрчилгээ” гэж бүтээгдэхүүн нь тогтоосон шаардлагад тохирч байгааг тодорхойлсон баримт бичиг олгохыг;

2.5 “Үл тохирол” гэж тогтоосон шаардлага үл биелж байгаа байдал;

2.6 “Нэмэлт үнэлгээ” гэж үл тохирлыг залруулсан байдалд хийх үнэлгээ;

2.7 “Магадлан хяналт” гэж тохирлын тунхаглалыг хүчин төгөлдөр байдлыг хадгалах; суурь болгож тохирлын үнэлгээний үйл ажиллагааг системтэйгээр давтан явуулах;

2.8 “Шинжээч” гэж үндсэн эрхэлдэг албан тушаал, ажил үүргийнхээ хүрээнд баталгаажуулалт явуулдаг ажилтныг хэлнэ;

2.9 “Шинжээчийн баг” гэж шаардлагатай үед техникийн шинжээчийн үнэлгээг явуулж буй нэг буюу түүнээс дээш шинжээч;

2.10 “Түдгэлзүүлэх” гэж баталгаанд хамрагдсан хүрээний бүх буюу тодорхой хэсгийг түр хугацаагаар хүчингүй болгох;

2.11 “Цуцлах” гэж тохирлын үнэлгээний тунхаглалыг хүчингүй болгох;

2.12 “Хөтөч” гэж захиалагчаас шинжээчийн багт туслахаар томилогдсон ажилтан;

2.13 “Зардал” гэж баталгаажуулалтын болон нэмэлт үнэлгээ, магадлан хяналт явуулах шинжээчийн багийн хоол, унаа, буудал гэх мэт холбогдон гарсан зарлага;

Гурав. Төлбөр, тооцоо

3.1 Баталгаажуулалтын ажил, үйлчилгээний төлбөрийн хэмжээг батлах тухай Монгол Улсын Шадар сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 22 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтад заасан “Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын ажлын төлбөрийн хэмжээ”-ний дагуу баталгаажуулалтын үнэлгээний төлбөр 138000 /нэг зуун гучин найман мянга/ төгрөг байна.

3.2 Дээрх “Бүтээгдэхүүн, үйлчилгээний баталгаажуулалтын ажлын төлбөр тооцоолох заавар”-ын 2.1.2-т заасны дагуу захиалагч нь үнэлгээний төлбөр болон үнэлгээтэй холбогдон гарсан зардлыг баталгаажуулалтын эцсийн шийдвэрээс үл хамааран төлж барагдуулна.

Дөрөв. Талуудын эрх, үүрэг

4.1 Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

4.1.1 Захиалагчид баталгаажуулалтын үнэлгээг олон улсын баталгаажуулалтын зарчим, хэм хэмжээг баримтлан ямагт шударга байдлыг хангаж, холбогдох стандарт, норматив баримт бичигт нийцүүлэн хараат бус, үл ялгаварлах, шударгаар мэргэжлийн өндөр төвшинд явуулна.

4.1.2 Үнэлгээний явцад үл тохирол илэрвэл захиалагчид цаг тухайд нь мэдэгдэнэ.

4.1.3 Үнэлгээгээр үл тохирол илэрсэн тохиолдолд тухайн үл тохирлыг залруулах хугацаа өгнө.

4.1.4 Үл тохирлыг залруулсан байдалд нэмэлт үнэлгээг гүйцэтгэж болно.

4.1.5 Захиалагч баталгаажуулалтын схемийн шаардлагыг бүрэн хангаж, баталгаажуулалт олгох шийдвэр гарсан тохиолдолд захиалагчид тохирлын гэрчилгээг олгоно.

4.1.6 Захиалагчийг баталгаажуулалтын шаардлагуудыг үргэлжлүүлэн хангаж байгаа эсэхийг тогтоохын тулд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус магадлан хяналтыг явуулна. Төлөвлөгөөт магадлан хяналтыг тохирлын гэрчилгээ олгосон өдрөөс хойш 12 сарын дотор явуулна.

4.1.7 Магадлан хяналт гүйцэтгэх шинжээчийн баг нь захиалагчийн барилга байгууламж, ажлын байранд урьдчилан мэдэгдэхгүйгээр ажлын цагаар саадгүй нэвтрэх эрхтэй.

4.1.8 Магадлан хяналтын үнэлгээний үед үл тохирол илэрсэн тохиолдолд “Баталгаажуулалтыг түдгэлзүүлэх, цуцлах, хамрах хүрээг багасгах журам”-ын дагуу арга хэмжээ авна.

4.1.9 Холбогдох стандарт болон норматив баримт бичгийн өөрчлөлт нь схемийн шаардлагад хамааралтай тохиолдолд тухайн өөрчлөлтийг мөрдөж эхлэх хугацаатай уялдуулан үйлчлүүлэгчид албан бичгээр эсвэл өөрийн веб хуудсаар мэдэгдэнэ.

4.1.10 Энэхүү гэрээний 4.1.9-т заасан өөрчлөлтийг хүчин төгөлдөр мөрдөж эхлэхэд захиалагч нь тухайн өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд бэлтгээгүй, бэлтгэсэн нь шаардлага хангаагүй бол “Баталгаажуулалтыг түдгэлзүүлэх, цуцлах, хамрах хүрээг багасгах журам”-ын дагуу арга хэмжээ авна.

4.1.11 Баталгаажуулалтад нөлөөлөх өөрчлөлт нь схемийн шаардлагад нийцэж буй эсэхэд төлөвлөгөөт бус магадлан хяналтыг явуулж болно.

4.1.12 Баталгаажуулалтын үнэлгээ явуулах үйл ажиллагааны явцад олж авсан нууцад хамаарах мэдээ, мэдээллийг зөвхөн хуулийн дагуу ил тод болсон, хэвлэлд нийтлэгдсэн, хуулиар шаардагдсан, захиалагчийн бичгээр өгсөн зөвшөөрлөөс бусад тохиолдолд задруулахгүй.

4.1.13 Шинжээчийн баг нь “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн 8.2 дах хэсэгт заасны дагуу ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй тохиолдолд ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ мэдэгдэнэ.

4.1.14 Үнэлгээний төлбөр болон баталгаажуулалттай холбогдон гарах зардлыг захиалагчид нэхэмжлэл хүргүүлж, шаардан гаргуулна.

4.1.15 Тохирлын гэрчилгээ олгосноор захиалагчийн үйл ажиллагаанаас үүдэн хэрэглэгчид учирсан хохирлын хариуцлагыг гүйцэтгэгч хүлээхгүй.

4.1.16 Баталгаажсан үйлчилгээний хамрах хүрээг өргөтгөсөн буюу багасгасан, тохирлын гэрчилгээнд аливаа өөрчлөлт орсон бол хуучин тохирлын гэрчилгээг шинэ тохирлын гэрчилгээгээр сольж олгоно. Энэхүү өөрчлөлтийг өөрийн цахим хуудаст бүртгэнэ.

4.1.17 Захиалагч тохирлын гэрчилгээг энэхүү гэрээнд заасны дагуу ашиглаж байгаа эсэхийг төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус магадлан хяналтаар шалгаж байна.

4.2 Захиалагчийн эрх, үүрэг

4.2.1 Гүйцэтгэгч талын “Баталгаажуулалтын үйл явцын журам”, “Баталгаажуулалтыг түдгэлзүүлэх, цуцлах, хамрах хүрээг багасгах журам”-тай танилцсан байна.

4.2.2 Гүйцэтгэгчийн баталгаажуулалтын тогтолцооны бүх баримт бичгийг чанд дагаж мөрдөнө.

4.2.3 Шинжээчийн багийн үнэлгээний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх бөгөөд баталгаажуулалтын үнэлгээ явуулахтай холбогдолтой баримт бичигтэй танилцахад бэлэн байлгана.

4.2.4 Шаардлагатай тохиолдолд шинжээчид туслах хөтчийг бэлэн байлгана. Хөтөч нь үнэлгээнд саад учруулах, үр дүнд нөлөөлөхийг хориглоно.

4.2.5 Шаардлагатай үед өөрийн нэгж бүрийн хариуцлагатай албан тушаалтныг бэлэн байлгаж, шинжээчийн багтай уулзуулна.

4.2.6 Баталгаажуулалтын үнэлгээ явуулсан шинжээчийн багаас гаргасан зөвлөмж, өгөгдсөн үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд биелүүлэх, шинжээчийн багт ажиллах байр, өрөө тасалгаа гаргаж өгнө.

4.2.7 Хэрэв үнэлгээгээр үл тохирол илэрч, гүйцэтгэгчийн заасан хугацаанд залруулах арга хэмжээ авсан бол үл тохирлыг залруулсан тухай тайлангаа гүйцэтгэгчид хүргүүлнэ.

4.2.8 Тохирлын гэрчилгээг зөвхөн баталгаажуулалтын хамрах хүрээнд гүйцэтгэсэн тохирлын үнэлгээний үр дүнг баталгаажуулахад ашиглана.

4.2.9 Баталгаажсан үйлчилгээг нийтлэх болон сурталчлахдаа тохирлын гэрчилгээг ашиглах эрхтэй.

4.2.10 Хэрэв тохирлын гэрчилгээний хуулбарыг бусдад өгөх бол зөвхөн эх хувиас нь бүрэн байдлаар хуулбарласан байна.

4.2.11 Баталгаажсан үйлчилгээг баталгаажуулалтад хамрагдаагүй үйлчилгээтэй андуурахгүй байх зорилгоор өөрийн гаргаж байгаа нийтлэл болон сурталчилгаандаа хяналт тавина.

4.2.12 Баталгаажсан үйлчилгээ нь баталгаажуулалтын схемийн шаардлагыг үргэлжлүүлэн хангаж ажиллана.

4.2.13 Тохирлын гэрчилгээг баталгаажуулалтад хамрагдаагүй үйлчилгээнд ашиглахыг хориглоно.

4.2.14 Тохирлын гэрчилгээнд дурдсан үйлчилгээний талаар хэрэглэгчээс гарсан өргөдөл, гомдол бүрийг бүртгэнэ. Мөн тухайн өргөдөл, гомдлыг хэрхэн барагдуулсан талаар бүртгэл хөтөлж, гүйцэтгэгчээс шаардсан үед бэлэн байлгана.

4.2.15 Тохирлын гэрчилгээтэй үйлчилгээг гүйцэтгэгчийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх байдлаар ашиглахыг хориглоно.

4.2.16 Гүйцэтгэгчийн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус магадлан хяналтад аливаа саад учруулахыг хориглоно.

4.2.17 Энэхүү гэрээний 4.1.9-т заасан мэдэгдлийг хүлээн авсны дараа тогтоосон хугацаанд тухайн өөрчлөлтийг хэрэгжүүлэхэд бэлтгэж байгаа эсэх тухай гүйцэтгэгчид албан бичгээр хүргүүлж мэдэгдэнэ.

4.2.18 Удирдлагын тогтолцоо, бүтэц зохион байгуулалт, үзүүлж буй баталгаажсан үйлчилгээний үйл явц ба үйл ажиллагаанд өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 5 хоногийн дотор гүйцэтгэгчид албан бичгээр мэдэгдэнэ.

4.2.19 Гүйцэтгэгчээс үйлчилгээнд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн мэдэгдэл өгөх хүртэл тухайн үйлчилгээнд тохирлын гэрчилгээ хэрэглэхгүй. Өөрчлөлттэй холбоотойгоор гүйцэтгэгчээс тавьсан шаардлагыг биелүүлнэ.

4.2.20 Баталгаажуулалтын хугацааг сунгуулах бол тохирлын гэрчилгээний хугацаа дуусахаас 2 сарын өмнө гүйцэтгэгчид албан бичиг хүргүүлж мэдэгдэнэ.

4.2.21 Тохирлын гэрчилгээний хугацаа дууссан болон баталгаажуулалтыг цуцлах шийдвэр гарсан тохиолдолд гүйцэтгэгчид ажлын 5 хоногийн дотор тохирлын гэрчилгээг гүйцэтгэгчид эргүүлэн өгнө.

4.2.22 Гүйцэтгэгч баталгаажуулалтыг цуцалсан болон түдгэлзүүлсэн тохиолдолд баталгаажуулалтыг аливаа нэгэн байдлаар ашиглахыг хориглоно.

Тав. Бусад зүйл

5.1 Энэхүү гэрээний заалтыг биелүүлээгүй тохиолдол тухайн шаардлагыг нөгөө тал албан бичгээр гаргана.

5.2 Талуудын хооронд үл ойлголцол гарсан тохиолдолд хэлэлцээрийн замаар шийдвэрлэнэ. Хэрэв хэлэлцээрийн замаар үл ойлголцлыг шийдвэрлээгүй бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

5.3 Захиалагч нь энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй бол түүнд урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр энэхүү гэрээг дуусгавар болох хугацаанаас нь өмнө цуцалж, хэвлэл, мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ.

5.4 Захиалагч нь үнэлгээний төлбөр болон баталгаажуулалттай холбогдон гарах зардлыг заасан хугацаанаас хойш ажлын 10 хоногийн дотор төлж барагдуулаагүй бол баталгаажуулалтыг цуцлах үндэслэл болно.

5.5 Баталгаажуулалт, баталгаажсан үйлчилгээний талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, гүйцэтгэгч болон захиалагчийн нэр хүндийг дээшлүүлэх чиглэлээр талууд идэвхтэй үйл ажиллагаа явуулна.

5.6 Гэрээний үндсэн эхийг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

5.7 Энэхүү гэрээ хоёр талын удирдлагууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн баталгаажуулалт дуусгавар болтол хүчин төгөлдөр үйлчилнэ.

5.8 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг хоёр тал харилцан тохиролцсоны үндсэн дээр шийдвэрлэнэ.

Гүйцэтгэгчийг төлөөлж:

АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН СУДАЛГАА ХӨГЖИЛ
ЧАНАРЫН УДИРДЛАГЫН ТӨВИЙН
ДАРГА
..... / /

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол
дүүрэг 20 дугаар хороо “Хөсөг тред”
ХХК-ны байр

Харилцах утас: 70070014

Захиалагчийг төлөөлж:

.....
.....
..... / /

Хаяг:.....
.....
.....

Харилцах утас: